


АЖИЛ ЭРХЛЭЛТ




Ажил эрхлэлт нь иргэдийн хамгийн тулгамдсан асуудал болж байгааг судалгааны дүн харууллаа. Судалгаанд хамрагдсан иргэдийн 282-т нь буюу 17,3 хувьд нь ажил, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бэрхшээл тулгарчээ. Тулгарсан асуудлыг нарийвчлан дараах графикт харуулав.



Энэ төрлийн бэрхшээлийг бүсээр нь харвал харьцангуй жигд тархалттай байгаа хэдий ч сумдад харьцангуй бага байна.



Хүйсийн хувьд голдуу эмэгтэйчүүд (эмэгтэй 57.4, эрэгтэй 42.6), насны бүлгийн хувьд 18-29 насныхан ажил эрхлэхэд илүү бэрхшээлтэй тулгарч байна. Харин энэ бэрхшээл 30-39, 40-49 насанд харьцангуй буурсан үзүүлэлт харагдав.




Бэрхшээл тохиолдсон гэх иргэдийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл:


23,4% нь бүтэн цагийн ажил эрхэлдэг, **31,9%** нь ажилгүй, **29,4%** нь хувиараа аж ахуй эрхэлдэг

Ажил эрхлэхтэй холбоотой бэрхшээлтэй тулгарсан иргэдийн 52,1 хувь нь шийдвэрлэх талаар ямар нэг оролдлого хийсэн бол 47,9 хувь нь ямар ч оролдлого хийлгүй орхисон байна.


Үүний шалтгааныг авч үзвэл:



Туслалцаа эрэлхийлсэн иргэдийн 15,4 хувь нь л хуульч, өмгөөлөгчид ханджээ.



Мөн шийдвэрлэх оролдлого хийсэн иргэдийн 29% нь бэрхшээлээ шийдвэрлэсэн, 42% нь хөөцөлдөхөө больж орхисон байна. Хөөцөлдөхөө больж орхисон шалтгааныг 30 гаруй хувь нь эерэг үр дүн гарна гэж итгэхгүй байсан гэж хариулжээ.



Бэрхшээлээ шийдвэрлэхээр хандсан иргэдийн талаас илүү нь нөгөө талтай ярилцаж, тохиролцох замаар гэж хариулжээ.



АСУУЛТ

- Энэ дүр зураг бодит байдалтай нийцэж байна уу?
- Иргэдэд ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хуулиар олгогдсон эрх, боломжийн талаар ямар мэдээллийг нэн түрүүнд хүргэх шаардлагатай вэ?
- Дээрх мэдээллийг ямар сувгаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?